

БАЙР СУУРЬ

СЭНДБОКС ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН ДАХЬ ФИНТЕКИЙН ТУРШИЛТ, ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ БОДЛОГЫН АРГА ХЭМЖЭЭ

Энэ удаагийн ярилцлагаар сэндрокс зохицуулалтын орчны талаар Санхүүгийн зохицуулах хорооны Зах зээл судалгаа, хөгжлийн газрын дарга Н.Оюунчимэгтэй ярилцлаа.



Сүүлийн жилүүдэд технологид суурилсан санхүүгийн үйлчилгээ зах зээлд нэвтэрч байгаатай холбогдуулан санхүүгийн зах зээлд сэндрокс зохицуулалтын орчны талаар яригдаж эхэлсэн. Сэндроксын орчны талаар та дэлгэрэнгүй тайлбар өгнө үү.

Технологид суурилсан санхүүгийн үйлчилгээ зах зээлд шинээр нэвтэрч санхүүгийн үйлчилгээнд шинэ хандлагыг бий

болгож байгаа бол нөгөө талаасаа одоо хэрэгжиж буй уламжлалт зохицуулалт төдийлөн тохиромжтой бус байна. Зохицуулалтын уламжлалт аргаар финтек бүтээгдэхүүнийг зохицуулах нь санхүүгийн байгууллагуудад болгоомжлол бий болгосноор шинэлэг бүтээгдэхүүн, дэвшил бий болоход саад учруулдаг. Түүнчлэн зохицуулагч байгууллага шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээ бүрд зориулан хууль тогтоомжийг байнга өөрчлөхөд ихээхэн хугацаа шаарддаг тул технологид суурилсан санхүүгийн үйлчилгээнд зохицуулалтын шинэ хэлбэр шаардагдах болсон. Үүний эсрэг авч хэрэгжүүлдэг инновацын төв (хаб) болон сэндрокс зохицуулалтын орчин гэсэн зохицуулалтын хэлбэрүүд байдгаас Санхүүгийн зохицуулах хороо санхүүгийн компаниудыг сэндроксын орчинд бүтээгдэхүүн, үйлчилгээгээ бодитоор турших боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.

Санхүүгийн үйлчилгээнд шинээр нэвтэрч буй технологид суурилсан шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээ, бизнес загварыг Зохицуулагч байгууллагын хяналт дор хязгаарлагдмал орчинд, тодорхой цаг хугацаанд туршихыг сэндроксын орчин гэж ойлгож

болно. Сэндроксын орчинд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ турших нь шинийг санаачлагчид, зохицуулагч байгууллага болон шинэ тоглогчдын аль алинд нь зохицуулалтын туршлага олж авах боломжийг олгодог.

Сэндроксын орчныг 2016 онд анх Их британи улс нь шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ гаргахад зарцуулах цаг хугацаа, зардлыг бууруулах, зах зээлд нэвтэрч буй бүтээгдэхүүний тоог нэмэгдүүлэх зорилгоор технологид суурилсан шинэлэг бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрэхээс өмнө туршихаар бий болгосон. Үүнийг хөгжингүй болон хөгжиж буй орнуудын зохицуулагч байгууллагууд санхүүгийн тогтвортой байдлыг хангах, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, түүнчлэн инновацыг бий болгохыг дэмжих тохиромжтой бодлогын арга хэрэгсэл хэмээн үзэж, дэлхийн 50 гаруй улс сэндроксыг нэвтрүүлж, түүний эрх зүйн орчныг бий болгож, туршилыг эхлүүлээд байна. Манай улс санхүүгийн зах зээлд технологид суурилсан шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрэхийг дэмжих зорилгоор Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн байгууллагууд болох Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Сангийн яам, Хадгаламжийн даатгалын корпорацын хамтарсан 2021 оны 3 дугаар сарын 01-ний өдрийн А-63/64/32/А/27 тоот тушаалаар “Сэндрокс зохицуулалтын орчны журам”-ыг баталснаар сэндроксын эрх зүйн орчин бий болж, санхүүгийн шинэ бүтээгдэхүүнийг аюулгүй орчинд туршдаг улс орны эгнээнд нэгдээд байна.

Сэндрокс зохицуулалтын орчны журам хэрэгжиж эхлээд жил гаруй хугацаа өнгөрсөн байна. Энэ хугацаанд ямар ажлууд хийгдсэн вэ?

“Сэндрокс зохицуулалтын орчны журам” нь 2021 оноос хэрэгжиж эхэлсэн. 2021-ээс 2022 онд нийт 12 байгууллага сэндроксын орчинд орох хүсэлт ирүүлснийг хянаж шаардлага хангаагүй 6 хүсэлтийг буцааж, нэр бүхий дөрвөн байгууллагын системтэй танилцаж, газар дээрх үзлэг хийгдсэн. Харин одоо 3 байгууллагын хүсэлт дээр хяналт, шалгалт хийж байна.

Сэндбоксын зөвлөлийн хуралдааныг 2021 онд 2 удаа зохион байгуулж, туршилтад оруулах 3 хүсэлтийг дүгнэлтийн дагуу хэлэлцсэнээс хоёр хүсэлтийг шийдвэрлэж, нэгийг нь түдгэлзүүлсэн. Одоогийн байдлаар технологид суурилсан 2 бүтээгдэхүүн, үйлчилгээ сэндбоксын орчинд амжилттай туршигдаж байна. Тухайлбал, “Мобифинанс” ХХК-ийн дижитал бондын арилжаа нь сэндбоксын орчинд туршигдсан анхны бүтээгдэхүүн бөгөөд 145 хөрөнгө оруулагчаас 1.0 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн. Харин “Мони маркет фонд ҮЦК” ХХК нь 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 02 дугаар шийдвэрийн дагуу сэндбоксын орчинд цахим платформор дамжуулан ББСБ-уудын хооронд репо хэлцлийн арилжааг зохион байгуулж эхэлсэн. 2022 оны 01 дүгээр сард нийт 5 удаагийн арилжаагаар 1.83 тэрбум төгрөгийн хэлцэл хийгээд байна. Ийнхүү зохицуулагч байгууллагын хяналт дор тодорхой хугацаанд шинээр гарч буй технологийн дэвшлийг ашигласан санхүүгийн үйлчилгээнүүдийг бодит орчинд туршсанаар уг бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрэхэд таниулж, мөн хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалж, тохиромжтой зохицуулалтыг боловсруулах боломжтой.

Сэндбоксын орчинд хүсэлт хүлээн авах, бүтээгдэхүүн, үйлчилгээг турших дүгнэлт гарган Зөвлөлд хүргүүлэх, хяналт шалгалт хийх Сэндбоксын нэгжийн чиг үүргийг Санхүүгийн зохицуулах хорооноос ажлын хэсэг байгуулагдан гүйцэтгэж байсан. Гэвч цаашид сэндбоксын орчинд туршилт хийх эрхзүйн орчин, дэд бүтцийг сайжруулахад бүрэн хариуцаж ажиллах чиг үүрэгтэй нэгж шаардлагатай болсон тул Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 207 дугаар тогтоолоор Сэндбоксын алба байгуулагдаад байна.

Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын шинэ бүтээгдэхүүн ямар шалгуурыг хангасан тохиолдолд сэндбоксад бүтээгдэхүүнээ турших боломжтой вэ? Сэндбоксад бүтээгдэхүүн, үйлчилгээг ямар хугацаанд туршдаг вэ?

Сэндбоксад оролцогч нь Монгол улсад бүртгэлтэй хуулийн этгээд байх бөгөөд санал болгох бүтээгдэхүүн нь зах зээлд шинээр нэвтэрч байгаа эсвэл ижил бүтээгдэхүүнүүдээс үр ашиг, өрсөлдөх чадварын хувьд илүү, шат дамжлага зардал багатай санхүүгийн үйлчилгээний хүртээмж болон хэрэглэгчдийн үр өгөөжийг нэмэгдэхэд чиглэсэн байх шаардлагатай. Мөн хэрэглэгчийн мэдээллийн нууцлалыг хангах, программ хангамж нь CISA сертификатын дагуу гүйцэтгэсэн аудитын тайланг эсвэл ISO27001 стандарт хангасан байх шаардлагыг тавьдаг. Сэндбоксын орчинд

оролцогчийн болон бүтээгдэхүүний шаардлагуудтай Санхүүгийн зохицуулах хорооны цахим хуудсанд байршуулсан “Сэндбоксын зохицуулалтын орчны журам”-аас илүү дэлгэрэнгүй танилцах боломжтой.

Сэндбоксын журмын хүрээнд сэндбоксад оролцогч нь 1 жилийн хугацаанд сэндбоксын орчинд бүтээгдэхүүн, үйлчилгээгээ туршдаг ба оролцогчийн хүсэлтэд үндэслэн дахин 1 жилээр сунгах боломжтой. Хэрэв оролцогч сэндбоксын туршилтад орох үед тохиролцсон хууль, эрх зүйн хязгаарлалтыг зөрчсөн, буруу ташаа мэдээлэл өгч, мэдээллийг нууцалсан нөхцөлд зохицуулагч байгууллагын шийдвэрээр эсвэл оролцогчийн хүсэлтээр хугацаанаас нь өмнө сэндбоксад орчноос гаргахаар тус журамд тусгасан.

“Сэндбоксад зохицуулалтын орчны журам”-ын хэрэгжилтийг сайжруулах, эрчимжүүлэх зорилгоор Сэндбоксын алба байгуулсан тухай та дээр дурдлаа. Тэгвэл Сэндбоксын алба байгуулагдсанаараа цаашид ямар ажил хийхээр төлөвлөж байна вэ?

Сэндбоксын алба нь дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Тухайлбал,

1. Эрх зүйн зохицуулалтыг сайжруулах ажлын хүрээнд Сэндбоксад зохицуулалтын орчны журмыг шинэчлэн батлуулах;
2. Сэндбоксын орчинд орох хүсэлт болон холбогдох санал, гомдлыг цахимаар хүлээн авах платформ (<http://license.frc.mn/>) нэвтрүүлэх;
3. Сэндбоксын орчинд орж буй бүтээгдэхүүнийг үнэлэх үнэлгээний арга, аргачлалыг боловсруулж батлуулах, хэрэгжүүлэх;
4. Сэндбоксын орчинд туршигдаж буй бүтээгдэхүүн үйлчилгээг зайнаас хянах рэгтекийг нэвтрүүлэх;
5. Бусад орны сэндбоксад зохицуулалтын орчны талаар олон улсын туршлагыг судлах, зөвлөмж, санал боловсруулах зэрэг болно.

Одоогийн байдлаар сэндбоксад орчны талаар олон улсад гарч буй шинэ туршилт, сайжруулалтын талаар судалж, мэдээллийн сан үүсгээд байна.